



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 8/648

Улаанбаатар хот

3.Хатанбаатарт сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.8, 48 дугаар зүйлийн 48.1.4 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3.4.4, 3.4.5, 6.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1, 10.10.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйлчилгээний Баянгол нэгдсэн төв дэх Улсын бүртгэлийн тасгийн иргэний улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Загдсүрэнгийн Хатанбаатар нь эрхэлсэн ажилдаа хайнга хандаж, 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын цагийг тасалсан тул түүнийг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгон төрийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсугай.


2.3.Хатанбаатарын иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Иргэний улсын бүртгэлийн газар /Г.Нармандах/-т даалгасугай.

3.Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг сануулахыг нууц хамгаалах ажилтан /Г.Анхныбаяр/-д үүрэг болгосугай.

4.3.Хатанбаатарын ажлыг зохих журмын дагуу хүлээлцэж, 516 дугаартай улсын бүртгэгчийн тэмдгийг хураан авч түр хадгалахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Н.Анхбаяр/-т, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

5.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

Handwritten signature and stamp of the Director, State Agency for Registration and Information of the Capital City of Ulaanbaatar, dated 10/12/2022.